



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/33

Баянтал сум

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.6, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өмнө нь газраа өмчилж авахаар захирамж гарсан иргэдийн газрын багийн хил зааг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 07 дугаар тогтоолоор өөрчлөгдсөн тул хавсралтаар батлагдсан жагсаалтын дагуу өөрчлөн өмчлүүлсүгэй.

2. Өмчилж авсан газраа үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх, өмчийн газраа бусдын өмчлөлд шилжүүлэх, ашиглуулах тохиолдолд эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч байхыг газар өмчлөгч иргэдэд үүрэг болгосугай.

3. Захирамжны биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газар зохион байгуулалт төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (Д.Мишээл)-д зөвшөөрсүгэй.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2012 оны 36 дугаар захирамжийн 99-138 дугаар бүртгэл, 2014 оны А/113 дугаар захирамжийн 127-157 дугаар бүртгэл, 2016 оны А/58 дугаар захирамжийн 36-42 дугаар бүртгэл, 2016 оны А/59 дүгээр захирамжийн 1-19 дүгээр бүртгэлийг хүчингүй болгосугай.

ДАРГА

Б.ГАНБАЯР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар

A/34

Баянтал сум

Цахилгаан дамжуулах агаарын шугамын
зурвас тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Говьсүмбэр аймгийн Баянтал суман Сүлд гэр хороололд хийгдэх цахилгаан дамжуулах агаарын шугамын зурвасыг хавсралтад заасан солбицлын дагуу тогтоосугай.

2. Уг байршлыг тогтоосонтой холбогдуулан Эрчим хүчний аюулгүй байдал, стандартын шаардлагыг хангуулж, хяналт тавин ажиллахыг сумын Засаг даргын орлогч Э.Эрхэмбаатарт үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ГАНБАЯР

2024 оны 3 сарын 10 өдрийн 1 дүгээр
захирамжийн хэвсрэлт.1

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЯНТАЛ СУМАН СҮЛД ГЭР ХОРООЛОЛД ХИЙГДЭХ ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ
АГААРЫН ШУГАМЫН ЗУРВАС


Д/д	Цэг	Координат	
		X	Y
6 кВ ЦДАШ			
1	Эхлэл	293263.17	5160040.6
2	Эргэлт	292097.56	5160238.42
3	Төгсгөл	291973.22	5161085.09
0.4 кВ ЦДАШ			
4	Эхлэл	291980.59	5161083.58
5	Эргэлт 1	292478.3	5161156.3
6	Эргэлт 2	292391.22	5161750.43
7	Эргэлт 3	292550.56	5160661.75
8	Төгсгөл 1	292141.89	5160602.04
9	Төгсгөл 2	292906.77	5160713.79
10	Төгсгөл 3	292968.1	5161227.86
11	Төгсгөл 4	291982.56	5161690.72
12	Төгсгөл 5	292881.02	5161821.99
6/0.4 кВ дэд өртөө			
13	Эргэлт 1	291974	5161091.85
14	Эргэлт 2	291977	5161091.83
15	Эргэлт 3	291973.99	5161089.08
16	Эргэлт 4	291976.99	5161089.07



2022 оны 5 сарын 27 өдрийн 134 тоот
захиармжийн хавсралт.1

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЯНТАЛ СУМАН СҮЛД ГЭР ХОРООЛОЛД ХИЙГДЭХ ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ
АГААРЫН ШУГАМЫН ЗУРВАС

Д/д	Цэг	Координат	
		X	Y
6 кВ ЦДАШ			
1	Эхлэл	293263.17	5160040.6
2	Эргэлт	292097.56	5160238.42
3	Төгсгөл	291973.22	5161085.09
0.4 кВ ЦДАШ			
4	Эхлэл	291980.59	5161083.58
5	Эргэлт 1	292478.3	5161156.3
6	Эргэлт 2	292391.22	5161750.43
7	Эргэлт 3	292550.56	5160661.75
8	Төгсгөл 1	292141.89	5160602.04
9	Төгсгөл 2	292906.77	5160713.79
10	Төгсгөл 3	292968.1	5161227.86
11	Төгсгөл 4	291982.56	5161690.72
12	Төгсгөл 5	292881.02	5161821.99
6/0.4 кВ дэд өртөө			
13	Эргэлт 1	291974	5161091.85
14	Эргэлт 2	291977	5161091.83
15	Эргэлт 3	291973.99	5161089.08
16	Эргэлт 4	291976.99	5161089.07





ГОБЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/35

Баянтал сум

Хүүхдийн төлөө зөвлөлийн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн орлогч дарга:

Зөвлөлийн гишүүд:

Засаг даргын орлогч

Засаг даргын Тамгын
газрын дарга

Ерөнхий боловсролын
сургуулийн захирал
4-р Цэцэрлэгийн

эрхлэгч

Эрүүл мэндийн төвийн
дарга

Соёлын төвийн дарга
“Талын илч”

ОНӨААТҮГ-ын дарга
Цагдаагийн хэсгийн

төлөөлөгч

Ахмадын хорооны
дарга

Лүн багийн Засаг дарга
Их-Уул багийн Засаг
дарга

Нарийн бичгийн дарга:


Нийгмийн бодлого
хариуцсан мэргэжилтэн

2.Зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэнд даалгасугай.

ДАРГА

Б.ГАНБАЯР





ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 4/36

Баянтал сум

Ажил хүлээн авах комисс томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжүүлэх журам”-ын 4.13 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн “Уссан /250мкуб багтаамтай/ өргөх станц магадлангийн зураг төсөв” ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Э.Түмэн-Эрдэнэ (Лүн 1-р багийн Засаг дарга)
Гишүүн: А.Батжаргал (“Талын илч” ОНӨААТҮГ-ын дарга)
Нарийн бичгийн дарга: М.Бодьгэрэл (Нийгмийн бодлого, худалдан
авах ажиллагаа хариуцсан
мэргэжилтэн)

2.Ажил хүлээн авах ажлын хэсэг гэрээнд заасны дагуу ажлын тоо хэмжээг тулган үзэж хүлээн авсугай.

3.“Уссан /250мкуб багтаамтай/ өргөх станц магадлангийн зураг төсөв”-ийг нялтан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу холбогдох байгууллага эд хөрөнгийн бүртгэл, валанс-д тусгахыг зөвшөөрсүгэй.

ДАРГА Б.ГАНБАЯР



ГОНЬСУМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/37

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1,17, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 33 дугаар зүйлийн 33.1.3, 48 дугаар зүйлийн 48.2.1, сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Сумын 2023 оны төсөв батлах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны Мал угаалгын ажил, үйлчилгээний зардал 3,254, 400(гурван сая хоёр зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуу) төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх зардалд шаардагдах 3,254, 400 (гурван сая хоёр зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуу) төгрөгийг Сумын орон нутгийн хөгжлийн сангийн “Малын тоо толгойн албан татвар”-ын зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (Б.Солонгомаа)-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын дарга (Т.Хишигням)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ГАНБАЯР



ГО БҮСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/38

Баянтал сум

Хүүхэд үрчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 Иргэний бүртгэлийн тухай хуулийн 11.5, Гэр бүлийн тухай 55.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянтал сумын Лүн 1-р багийн иргэн Боржигон овогт Жанчивын Баасансүрэн (HE71031978), Боржигон овогт Сампилноровын Отгонбаяр (HE72111160) нар нь өөрийн төрсөн охины хүүг Санчирыг (ХВ21280852) үрчлэн авах хүсэлтийг харгалзан үзэж Боржигон овогт Баасансүрэнгийн Энхжаргал (ЦХ96040801) нь үрчлүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль тогтоомжид заасны дагуу Э.Санчирыг өөрийн төрсөн хүүхдийн адил тэжээн тэтгэж, өсгөн хүмүүжүүлэхийг (Ж.Баасансүрэн), (С.Отгонбаяр) нарт үүрэг болгосугай.

3.Энхжаргалын Санчирыг Баасансүрэнгийн Санчир болгон холбогдох хууль, журмын дагуу бүртгэл хийж гэрчилгээ олгохыг Баянтал сум хариуцсан Улсын бүртгэгч (Б.Цэрэнням)-д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн (М.Бодьгэрэл)-д даалгасугай.

ДАРГА

Б.ГАНБАЯР



ГОУСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/39

Баянтал сум

Асран хамгаалагч, харгалзан
дэмжигчээр тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гэр бүлийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1, 26.8 64. 13 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Намжилдорж овогтой Анужин /рд 21231105УР/охинын асран хамгаалагч харгалзан дэмжигчээр түүний төрсөн эмээ болох Жадамбаа овогтой Нарангарав /рд:770521023Н/-ыг тогтоосугай.
2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн (М.Бодьгэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ГАНБАЯР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 7/40

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн "Сумын төсөв батлах тухай" 06 дугаар тогтоол, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3.3, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн "Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Онцгой комиссын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 04 дүгээр хуралдаанаар хэлэлцэж, дэмжигдсэн төсөл арга хэмжээний хөрөнгийн зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 6,000,000 (зургаан сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн Гамшгаас хамгаалах зардлаас санхүүжүүлэхийг Санхүү албаны ерөнхий нягтлан бодогч (Б.Солонгомаа)-д зөвшөөрсүгэй.

3. Тус ажлын хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Хишигням)-д даалгасугай.

ДАРГА



Б.ГАНБАЯР

Баянтал сумын Засаг даргын
2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн
1/10 дугаар захирамж

ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	АРГА ХЭМЖЭЭ	ТӨСӨВ ӨРТӨГ
1	Сэг зэм устгах ажилд зарцуулах шатахуун	1,000,000
2	Сэг зэм устгах ажилд хэрэглэгдэх халдвар хамгааллын хувцас худалдан авах	1,500,000
3	Сэг зэм устгах ажилд автомашин хөлслөх, түрээслэх	3,500,000
	Бүгд	6,000,000



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/41

Баянтал сум

Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн
хүүгийн орлого зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, ХХААХҮСайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх хяналт тавих журам”-ын 2.7 дах заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Сангаас олгосон зээлийн хүүгийн өмнөх жилийн орлогын 50 хүртэл хувийг хууль тогтоомжид нийцүүлэн захирамжийн хавсралтын дагуу зарцуулахыг зөвшөөрсүгэй.

2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан хүүгийн орлого 2400000 (хоёр сая дөрвөн зуун мянга) төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангаас зарцуулахыг Нягтлан бодогч / Б.Солонгомаа /-д зөвшөөрсүгэй

3. Сангийн зээлийн хүүгийн орлогын зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Хоршоо хөгжүүлэх сангийн хяналтын хорооны дарга (Х.Мөнхбаатар) -т үүрэг болгосугай

ДАРГА

Б.ГАНБАЯР



Засаг даргын 2024 оны 07 дугаар
сарын 22 ны өдрийн 17 дугаар
захирамжийн хавсралт

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн орлогын зарцуулалт

№	Зардлын ангилал	Мөнгөн дүн
1	Сургалт сурталчилгаа	1200000
2	Программ хангамж	510000
3	Төслийн үр дүн, хяналт шалгалт	340000
4	Хоршоо хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн урамшуулал	350000
	Нийт / төгрөг /	2400000